

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2022 оны 06 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 4 608 243 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4 914 678 мян.төгрөг төвлөрүүлж, 106 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 620 386 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1 184 962 мян.төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 91 хувиар давуулан биелүүлж, сумын төсвийн орлогод 3 060 917 мян.төгрөг төвлөрүүлэхээс 2 708 822 мян.төгрөг төвлөрүүлж, 110 хувийн биелэлтэй байна. Мөн аймгийн төсвийн орлогод 759 450 мян.төгрөг төвлөрүүлэхээс 973 370 мян.төгрөг төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөсөн хэмжээнээс 28 хувиар давуулан биелүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 642 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 689 болж өссөн байна. Үүнд: ХК-1, ХХК-356, ББН-5, ЗБН-9, Хоршоо- 29, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ- 6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-216 байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 75 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 98.9 хувьтай байна.

Сум дундын ойн ангийн 2021-2022 оны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, хүний нөөцийн үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Шалгалтаар тус байгууллагын үйл ажиллагаа нь байгууллагын стратеги төлөвлөгөөг журмын дагуу боловсруулаагүй, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй, дотоод хяналтын тогтолцоо эхлэлийн түвшинд, хүний нөөцийн бодлогогүй, бүтэц орон тоо цөөн, ажлын ачаалал их, ажил үүргийг оновчтой хуваарилаагүй зэргээс үзэхэд тус байгууллагын үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй байна гэж дүгнэгдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд хугацаатай 21 зөвлөмжийг өгч, албан тоотоор хүргүүлсэн.

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2020-2021 он, Боржигин чуулгын 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Хяналт шалгалтын явц 90 хувьтай байна.

Цөм сүрэг үржлийн төвийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтын явц 30 хувь, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтын явц 70 хувь, Аймгийн хөрөнгө оруулалтын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтын явц 50 хувьтай байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 3 хөмрөгийн 11 хадгаламжийн нэгжийн 816 хуудас, 372 заалт, 2347 хүний нэр, 1121 газар зүйн нэр, 816 хуудас баримтыг программд холбосон.

Тайлант хугацаанд 12 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 15
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 34
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 29
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 7
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1

- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 13
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 18

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 11
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 40
- Гэрээний бүртгэл - 42
- Барьцааны гэрээний бүртгэл - 137
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга – 8

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 5
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 38

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 49
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 8
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 318

Нийт 375 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Цагдаагийн хэлтэс: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2022 оны тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 130 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 32, зөрчлийн 98 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 25 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 3’710’000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 53 хүнийг эрүүлжүүлж, 25 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 41 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 128 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр сүмбэр сумын нутаг дэвсгэрт найрамдал хотхон, дэнж, төмөр зам, аяганы хонхор чиглэлд өдөр 10:00-18:00, орой 18:00-02:00 цагуудад, Баянтал сум, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт 10:00-16:00 цаг, 18:00-00:00 цагийн хооронд эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 248 алба хаагч 1984 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Гудамж талбай, олон нийтийн газар болон авто замд зөрчил гаргасан 1555 хүнийг 33’275’000 төгрөгөөр торгож ажиллалаа.

Энэ оны 06 дугаар сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, байгууллагын вэб хуудасны мэдээллийг шинэчлэн, “Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс” пэйж хуудас болон фэйсбүүк хуудсанд постер 63, зурагт мэдээлэл 52, видео 25, анхааруулга, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж 381-ийг тус тус иргэд олон нийтэд хүргэж ажиллалаа.

Мөрдөн байцаах алба, Урьдчилан сэргийлэх хэлтсээс “Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээг төлөвлөгөөний дагуу 2022.06.13-ны өдрөөс 2022.06.27-ны өдрийг хүртэлх хугацаанд хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгууллаа.

Бага насны явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул ослоос сэрэмжлүүлэх зорилгоор “**Явган зорчигчийн аюулгүй байдал-сургууль орчмын бүс-**

хүүхэд” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд хяналт шалгалтын ажлыг явуулав. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан хүүхдийн орчны эрсдлийг бууруулах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан ажлын мэдээллийг танилцуулж, холбогдох байгууллагуудтай санал солилцож ажиллав.

Эрх бүхий албан тушаалтнуудаас бэлэн бусаар торгож шийдвэрлэсэн торгуулийг эргэн төлүүлэх, сайн дураар торгууль төлөөгүй иргэдийн торгуулийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх зорилгоор “Эргэн төлөлт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

Мөн Замын цагдаагийн тасгаас “Арлын дугаар”, “Оношлогоо”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Хамгаалах малгай”, “Согтуу”, “Уусан бол бүү жолоод” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж үр дүнг тооцов.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил” сэдвээр подкаст ярилцлага бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Монгол улсын ерөнхий сайдын саначлагаар зохион байгуулагдсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аян, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд заагдсаны дагуу “Хорт зуршлаас татгалзаж-сайнаар үлгэрлээ” нөлөөллийн аянуудын хүрээнд цагдаагийн хэлтсийн алба хаагчид аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар явган аялал зохион байгууллаа.

Олон улсын “хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээний үеийн хамгаалалтыг зөрчилгүй зохион байгуулж ажиллав.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар Аймгийн прокурорын газраас зохион байгуулсан хамтарсан зөвлөгөөнд цагдаагийн хэлтсийн Эрх бүхий албан тушаалтнууд оролцов.

Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан зохион байгуулсан “хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах нь” сургалтанд эрх бүхий албан тушаалтнууд хамрагдлаа.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Биеийн тамир спортын газраас хамтран Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар баг буюу хөдөөгийн багуудын малчдын дунд зохион байгуулсан “Хөдөөгийн баясгалан” өдөрлөгийг тус сумын 5 дугаар багийн Уулзварын гол гэх газар зохион байгуулж, арга хэмжээнд 250 орчим малчин иргэд хамрагдлаа. Цагдаагийн хэлтсээс 5 алба хаагч оролцож, хэв журам сахиулах, хамгаалалт, хөдөлгөөн зохицуулалтын үүрэг гүйцэтгэсэн ба “Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, ухуулга хийж, хууль сурталчлан, гэр бүлийн хүчирхийллээс болон зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн 100 сэрэмжлүүлэг тарааж ажиллав.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 14 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 3, зам тээврийн ослын 4, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 251 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Мэргэжлийн хяналтын газар нь: Иргэний хүсэлтийн дагуу мах, махан бүтээгдэхүүний 2 цехэд Эрүүл ахуй, Мал эмнэлгийн, Хүнсний чанал стандартын хяналтын чиглэлээр хамтарсан урьдчилсан хяналт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчил арилгуулах 8 заалт бүхий албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

Аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Ахмадын өргөөний барилгын ажлын зургийг хянаж, 5 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгаж, зурагт дутуу зүйлийг тусган дахин хянуулах тухай албан тоотоор мэдэгдэж, уг барилгын зураг төсөлд илэрсэн зөрчил нь

холбогдох хуулийн заалтад бүрэн нийцэхгүй тухай дүгнэлт гарган хүргүүлэв. Мөн худалдааны төвийн барилгын ажлын зургийг хянаж дүгнэлт гарган хүргүүлсэн.

МХЕГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02/08 дугаартай удирдамжийн дагуу "Хүүгийн вет", "Хуягт халтар" ХХК-д Мал эмнэлгийн нэгжийн аж үйлчилгээ явуулхаар хүсэлт гаргасаны дагуу 1.15.1 Ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээний мал эмнэлгийн нэгжийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Мал эмнэлгийн Ерөнхий газраас ОХУ-д үйлдвэрлэгдсэн 050222 серийн дугаартай 2022 оны 02-р сард үйлдвэрлэгдсэн 2024 оны 2-р сард хугацаа нь дууссах мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 48 мян.тун буюу 96 литр, 19 хайрцаг 5 фл-ыг том оврийн хүргүүтэй машинд +40 С температурт ачиж ирж буулгахад хяналт тавьж ажиллав.

Баяннекус ХХК-д төлөвлөгөөт бус шалгалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, Хөдөлмөрийн эрүүл ахуйн, Барилга техник хяналтын улсын байцаагчид хамтран 04 дүгээр сарын 15-ны өдөр хийж, 49 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага болон, үйл ажиллагааг түр түдгэлзүүлээд байна.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн 45 сорьцонд 173 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэн хяналт тавьж, хариуг баталгаажуулсан. Шаардлага хангаагүй сорьц илрээгүй.

Хуваарийн дагуу лабораторийн гаднах 50 м орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн. Аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн 45 сорьцонд 173 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэн хяналт тавьж, хариуг баталгаажуулсан. Шаардлага хангаагүй сорьц илрээгүй.

Онцгой байдлын газар нь: Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн 1 дуудлага, гал түймрийн зөрчлийн 1 дуудлага, эрэн хайх аврах ажиллагааны 4 дуудлагатай байлаа.

Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, Хий цэнэглэх станцуудын барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах" төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав. Шалгалтаар 22 ААНБ-ыг хамруулж, нийт 174 зөрчил илрүүлэн газар дээр нь 24 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 22-ыг, дүгнэлт 1, мэдэгдэл 2-ыг хүргүүлсэн.

"Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө"-ний дагуу ангиллын сургалтыг Төрийн болон Төрийн бус байгууллагын нийт 8 байгууллагын 186 ажилтан алба хаагчдад зохион байгуулсан байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Элсэлтийн нэгдсэн шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд шалгалтыг 10 хичээлээр зохион байгуулж, нийт 500 сурагч хамрагдсан.

2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Элсэлтийн нэгдсэн шалгалтад бэлтгэх сайн туршлагаа хуваалцъя" зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 54 багш, удирдах ажилтан оролцлоо.

"Боловсролын чанарын шинэчлэл" төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд, бага боловсролын сургалтын менежерүүдийг чадавхжуулах, туршлага судлах ажлыг зохион байгууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэдэх "Ёс зүйн хороо"-ны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд "Ёс зүйн хороо"-ны 9 гишүүн

хамрагдаж, гишүүдийн хамтран ажиллах ажлын чиглэл, ажлын төлөвлөгөөний саналыг хүлээн авч, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Цагдаагийн хэлтсээс "Хүүхдийг зам тээврийн осол гэмтэл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх" зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, Боловсролын шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Улаан загалмайн хороотой хамтран ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтнууд, эмч, эцэг эхийн зөвлөлийн дарга, сургуулийн нөлөөллийн бүлгийн ахлагч сургуулийн өмнөх боловсролын арга зүйч нарыг хамруулан "Сурагчийн аюулгүй байдалд эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 37 багш, арга зүйч, эцэг эх, сурагчид хамрагдсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Нэгдүгээрт хүүхэд уриан дор "Хүүхдийн эрх, үүрэг, оролцоо хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Багшийн харилцаа-хандлага", "Эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа-хандлага" сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд зохион байгуулсан. Сургалтад 200 багш, ажилтан, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 100 эцэг, эх хамрагдсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан морин хуурын дугуйлангийн багш Төв Халхын алдарт хуурч МУСТА Базарын Банзрагчийн нэрэмжит өсвөрийн болон залуу морин хуур сонирхогчдын аймгийн уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Тус уралдаанд ерөнхий боловсролын сургуулийн 4 насны ангилалд нийт 15 сурагч оролцсон.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүүхэд эрхэм хэрэглэгч" нөлөөллийн аяныг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус аяны хүрээнд орчны аюулгүй байдлыг шалгах, хангах чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 75 эцэг эх, 17 хүүхдийг хамруулсан Мөн хүүхдийн эрсдлийн түвшин тогтоох программд бүртгэлтэй 256 хүүхдийн 150 өрхийн гэрээр айлчилж, эрсдэлийн үнэлгээ хийн, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Өсвөр үеийн залуус мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан "Шинэ Түүх - New Story" хөгжлийн хөтөлбөр, улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын үндэсний аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр сургалт зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид болон Уул уурхайн жишиг сургууль Политехник коллежийн 331 оюутан, сурагч оролцсон.

Соёл, урлагийн чиглэлээр: Аймгийн Соёл, урлагийн газраас "Угийн бичиг хөтлөлтийн талаарх зөвлөлдөх уулзалт"-ыг зохион байгууллаа. Уг уулзалтад нийт 35 иргэн хамрагдсан.

Аймгийн Нийтийн номын сан нь 15 номыг ном бүрдүүлэх жагсаалтад бүртгэж, уншигчдын шаардлагатай 120 нэр төрлийн 416 ширхэг 6,595,478 төгрөгийн үнэ бүхий номыг худалдан авч номын фондоо баяжуулсан.

ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийг яаралтай хамгаалах өвийн жагсаалтад орсон "Шагайн харваа"-н өвийг оршин тогтнох чадварыг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд "Шагайн харваачид" үзэсгэлэнг зохион байгуулсан.

Биений тамир, спортын чиглэлээр: Орон даяар зохион байгуулагдаж байгаа "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны хүрээнд өглөө бүр байгууллагуудын заалны хуваарийг гаргаж, иргэдийг үнэ төлбөргүй хичээллэх боломжоор хангаж, одоогийн байдлаар 48 байгууллагын 4499 иргэн хамрагдаад байна.

Монголын бүх ард түмний спортын XV их наадмын хүрээнд Волейбол, Пауэрлинг, сагсан бөмбөг, хөлбөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2021 оны 04 сар	2022 оны 04 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	144	98
Гэрийн төрөлт	2	0
Амьд төрсөн хүүхэд	148	97
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	27	31
Эмнэлгийн нас баралт	7	6
Хоног болоогүй нас баралт	4	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	1204	2513
Амбулаторийн үзлэг	30752	29578
Халдварт өвчин	50	2195

Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт техник технологийг нутагшуулах, түүний ашиглалт хэрэглээг өргөжүүлэх замаар иргэд, үйлчлүүлэгчид орон нутагтаа бүрэн оношлогдох, тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор эмнэлгийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах хамтарсан эмчилгээ, сургалт зохион байгууллаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Тайлант сард ажил олгогч нарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг сурталчилж, шинээр бий болсон 6 байнгын ажлын байрыг бүртгэж, өссөн дүнгээр 38 ажлын байрыг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шинээр 40 иргэнийг бүртгэж, 175 иргэний мэдээллийг шинэчлэн бүртгэж, өссөн дүнгээр мэдээллийн нэгдсэн санд 321 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэлтэй байна.

Ажил олгогч аж ахуй нэгж, байгууллагаас 48 нээлттэй ажлын байрны захиалга хүлээн авч, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж, ажил хайгчаар бүртгэлтэй 36 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлаад байна.

Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй 20 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт хийсэн ба орон нутгийн хэмжээнд 25-аас дээш ажилтантай 37 аж ахуйн нэгж, байгууллага /төрийн болон орон нутгийн өмчит-30, хувийн аж ахуйн нэгж-7/ байна. Хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ХБИ ажиллуулж буй 24 байгууллага /төрийн болон орон нутгийн өмчит байгууллага-19, хувийн аж ахуйн нэгж-5/, хуулийн хэрэгжилтийг хангаагүй-13 байгууллага /төрийн болон орон нутгийн өмчит байгууллага-11, хувийн аж ахуйн нэгж-2/ байна.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, эргэн төлөлтөд 12358,0 төвлөрүүлж, өссөн дүнгээр 108 хүний 58251,5 мян төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна.

2021 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 37 төслийн хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалтыг хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар төллөвөл зохих 165,206 эх малаас төллөсөн 115158, гарсан төл 115286, үүнээс бойжиж байгаа төл 114453, мал төллөлт 69.7 хувь, төл бойжилт 99.3 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол 816 байна. Аймаг дундын Малах отрын бүс нутагт 51 малчин өрхийн хонин толгойд шилжүүлснээр 39.0 мян.тол мал оторлож байна.

Сүмбэр сумын 6-р багийн өдөрлөг болон малчдын хаваржилтын байдалтай танилцаж, нийт 122 малчин өрхөд мал аж ахуйн технологит ажлын болон цаг үеийн мэдээллийг хүргэсэн.

Монгол улсын Засгийн газраас 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хоршоо, аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлогыг шат дараатай авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг эхлүүлж, сум хөгжүүлэх сангийн өмнөх зээлийн хугацаа хэтэрсэн, чанаргүй муу зээлийн ангилалд байгаа 83 зээлдэгчийн 711,390,379 төгрөгийн зээлийн үлдэгдлийг шүүх, прокурорын байгууллагатай хамтран барагдуулах арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг сумдад чиглэл болголоо.

Аймгийн дүнгээр мах 39 тн буюу 23, гурил 85.3 тн буюу 61, сүү 3.6 тн буюу 2, төрөл бүрийн будаа 15.9 тн буюу 23, төмс 9.1 тн буюу 5, хүнсний ногоо 10.3 тн буюу 3, элсэн чихэр 8.3 тн буюу 18, давс 6.1 тн буюу 22, савласан ус 25 тн буюу 1, өндөг 3 тн буюу 11, ургамлын тос 7.9 тн буюу 25 хоногийн нөөцтэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 4 дүгээр сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 150-2500 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /ястай/ 500 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, лууван 250 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр, байцаа 150 төгрөгөөр, чинжүү 2500 төгрөгөөр, манжин 300 төгрөгөөр, элсэн чихэр 150 төгрөгөөр, цагаан будаа 200 төгрөгөөр, тараг /задгай/ 250 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 500-1000 төгрөгөөр, Төмс, хүнсний ногоо 250-500 төгрөгөөр, Сүү 1000 төгрөгөөр, Гурил 50-150 төгрөгөөр нэмэгдсэн бол импортын бүтээгдэхүүн болох Элсэн чихэр 200 төгрөгөөр, Цагаан будаа 500-1000 төгрөгөөр, Ургамлын тос 1000-1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /3-р сараас /
1	Үхрийн мах	Ястай	13000	11000	-
		Цул	15000	14500	+500
2	Хонины мах	Ястай	9500	9000	-
		Цул	12000	11000	-
3	Адууны мах	Ястай	8500	8000	-
		Цул	10000	10000	+500
4		Ястай	8500	7500	+500

	Ямааны мах	Цул	11000	10000	-
5	Лууван	монгол	3500	3000	+250
		хятад			
6	төмс	монгол	1500	1300	+250
		хятад			
7	Байцаа	монгол	3500	3000	+150
		хятад			-
8	чинжүү	монгол			-
		хятад	18000	12000	+2500
9	Манжин	монгол	2500	1800	+300
		хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	3800-	1500	-
11	Помидор	монгол	13000	8000	-
12	Өргөст хэмх	монгол	15000	12000	-
13	Элсэн чихэр		3500	3000	+150
14	Будаа	Цагаан задгай кг	4000	3000	+200
		Шар слава кг	3800	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3900	3750	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	3500	3000	+250
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	2500	1500	-
18	Өндөг	Монгол	550	440	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1800	1480	-
		Задгай 1-р зэрэг	1650	1280	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
	Ургамлын тос	Олейна	8800	7500	-

20		Алтан	6500	4500	-
----	--	-------	------	------	---

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 13 дугаар тогтоолоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд манай аймагт ажиллаж, Чойрын Богд уулын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 9.8 дахин томсгохоор болсон. Аймгийн хэмжээнд нийт 18 байршлын 206899.35 га газар улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад байдаг. Үүний 0,68 хувь буюу 3814 га газар нь улсын тусгай хамгаалалтад, 203 орчим мянган га газар аймгийн тусгай хамгаалалтад байдаг байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Улсын хэмжээнд кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж байгаа бөгөөд аймгийн хэмжээний иргэн, хуулийн этгээдийн нөхөн бүрдүүлэлтийн мэдээллийг кадастрын мэдээллийн санд оруулах ажлыг эрчимжүүлэхээр ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Сумдын газрын үнэлгээ, газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох ажлын хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, “Хууль зүйн яам”-нд бүртгүүлэхээр ажиллаж байна.

Газрын төлөв байдал, чанарын улсын захиалгат хянан баталгааны ажлыг 5 жил болсон иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар хийлгүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Баталгаажуулсан тайлан- 41 нэгж талбар
- Буцаагдсан тайлан- 5 нэгж талбар
- Нийт- 46 нэгж талбарын тайлан дүгнэлтийг хүлээн авч 86 нэгж талбарт мэдэгдэх хуудсыг хүргүүлэн ажиллаж байна.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч нарт зориулсан “Газрын харилцааны хууль тогтоомжийг сурталчлах, мэргэжил арга зүйн зөвлөгөө” өгөх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр аймгийн зохион байгуулан ажилласан. Уг сургалтад 3 сумын 38 төлөөлөгч оролцсон.

Сүмбэр, Баянтал суманд 2022 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдөр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулан ажиллалаа.

Уг өдөрлөгөөр иргэд, олон нийтэд газрын харилцааны цахим шилжилт болох www.egazar.gov.mn цахим сайтын талаар болон сумдын 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг танилцуулан иргэдэд зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн.

Барилга хот байгуулалтын чиглэлээр: Сумдын Засаг Даргын Тамгын газрын дарга нар, хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдэд “Хөрөнгө оруулалтын ажлуудын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг 2022.03.24-ний өдөр зохион байгууллаа.

Худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд нийт 919,592.6 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 41 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 31 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны явц 73.1 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 12 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 17 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 12 ажил, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар

нийт 1 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус цахимаар зарлаад байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт цахим системд оруулан ажиллаж байна.

Орон нутгийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг 43 хуулийн этгээдэд өгч, 2021 оны жилийн эцсийн хөрөнгийн мэдээ тайланг нэгтгэн, хууль, журмын хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.

2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлого 7.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: 2022 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд хөдөөгийн малчдын хаваржилтын цагийн байдалтай танилцаж, малчидтай уулзаж, мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын дархлаажуулалтын ажлын зөвлөмж өгч, үүрэг чиглэл өглөө.

Сумын хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдардаг 4 өрхийн 16 хүүхдэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хүнсний тусламж үзүүлэв.

Аймгийн Мэргэлийн хяналтын газар, Худалдаа, аж үйлдвэрийн танихимтай хамтарч худалдаа, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгчдэд “Хүнсний аюулгүй байдал”, “Ажлын байрны стандарт” сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий Сайдын санаачилсан “**Илүүдэл жингүй-Эртэч монгол**” аяныг сумын хэмжээнд хэрэгжүүлж байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 2929 толгой үхэр хамрагдахаас одоогийн байдлаар 1080 үхэр хамрагдаж 36,7 хувьтай явж байна.

Шивээговь сум: Аж ахуй нэгж албан байгууллагын бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, 5 байгууллагын 30 ажилтан албан хаагч хамрагдаж, нийт хагас тн хог хаягдал ачиж зөөсөн.

9-15 байрны ойр орчим, уурхайн конторын ойр орчим, уурхайн грашын ойр орчим зэрэг газруудад 120 ажилтан албан хаагч цэвэрлэгээнд оролцож 6000кг хог хаягдал түүж, цэвэрлэсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд суманд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 5000-аас доошгүй мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлийн дагуу 2022 онд бүх нийтээр мод тарих төлөвлөгөөг сумын иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад танилцууллаа.

Сүмбэр сум: Дорноговь аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэстэй 04-р сарын 12-16-ны өдрүүдэд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнс худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 47 иргэн, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээнд хяналт үнэлгээ хийж, тэдгээрт ашиглаж байгаа 54 жин хэмжүүр, Өрхийн эрүүл мэндийн төв, 3 сургууль, 4 цэцэрлэг, түүхий эд бэлтгэлийн 5 цэг, 4 барилгын материалын 10 дэлгүүр, шатахуун түгээх станцын шингэн хэмжигч, 4 авто пүү, нийт 86 хэмжих хэрэгслийг баталгаажуулж, аймгийн тохирлын үнэлгээний салбар зөвлөлийн хурлаар 5 иргэн, аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн.

E-mongolia.mn системээр дамжуулан 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 575 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Архины хэрэглээг бууруулах замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний архидалтыг бууруулах, архины хамааралтай иргэд, тэдний гэр бүлийг соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулж буй “Архидалтгүй сүмбэр 3” арга хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг

зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн хэлтэс, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж 16 иргэнийг хамрууллаа.

Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй өсвөр залуу үеийнхэнд интрепренершипийн бололсрол олгох хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль дээр “Эрүүл бүхээг”, “Дижитал стори”, “Оюуны наран” төслүүдүүдийг хэрэгжүүлэхээр болсон.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг 04 дүгээр сарын 06,07-ны өдрүүдэд 5 дугаар багийн 41 өрх, 6 дугаар багийн 32 малчин өрхөөр явж, хаваржилтын болон мал төллөлтийн байдалтай газар дээр нь танилцлаа. Ажлын хэсэг мал төллөлт, хаваржилтын байдалтай танилцаж, төлийн болон том малын хорогдлын мэдээг газар дээр нь авч, багийн иргэдэд бэлчээр ашиглалтын журмын танилцуулан, малчдад зориулсан гарын авлага, дүрэм журмын талаар богцтой мэдээлэл бэлтгэн хүргэж, өөр аймаг, сумаас өвөлжихөөр отроор орж ирсэн 2 малчин өрхөөр орж сумын Засаг даргын албан мэдэгдлийн дагуу хугацаандаа нүүх талаар мэдэгдэл өгсөн.

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Гоц халдварт шүлхийгээс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай” А/113 дугаар захирамжийн хүрээнд Сүмбэр сумын 4, 5, 6-р багийн 82 малчин өрхөөр орж, отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн болон малын гоц халдварт шүлхийгээс сэргийлэх вакцинжуулалтад малаа идэвхтэй хамруулах талаар ухуулга сурталчилгаа хийж, малын гоц халдварт 4 төрлийн өвчнөөс сэргийлэх 100 ш гарын авлага тараасан.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 145 байгууллага, хашаатай 998 айл өрхүүд өөрийн эзэмшлийн талбайд мод тарьж, ургуулах, эзэмшил газар нь мод тарих талбайгүй иргэд, ААНБ-ууд сумын 6 цэцэрлэгт хүрээлэнд мод тарихаар, мөн замын баруун талд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд өөрийн эзэмшлийн талбайд болон эзэмшил талбайн ойролцоо газруудад 8 жилийн хугацаанд тус бүр 8000 мод тарихаар төлөвлөж, зураг төслийг гаргаад байна.

Сумын Засаг даргын А/66 дугаар захирамжаар айл өрх бүр эзэмшил газартаа болон нийтийн эзэмшлийн талбайд мод тарих, бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын мод тарих хуваарийг гарган баталж, төвийн 3 багийн төрийн 34 байгууллага, хувийн хэвшлийн 30 байгууллагад хуваарийг хүргүүлсэн.

Сумын Засаг даргын А/67 дугаар захирамжийн дагуу “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГазар нь золбин нохой, муур устгалын ажлыг зохион байгуулж, 311 золбин нохой, 32 муурыг устгасан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР